



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/138

Дадал сум

**Эзэмшил газрын байршил шилжүүлэх
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Баян-Овоо багийн Тэмүүжин гудамж 219 тоот хаягт иргэн Сүхбаатарын Уянгын худалдаа үйлчилгээний зориулалтаар эзэмшиж байгаа 270м² газар нь шинээр хийгдэх инженерийн дэд бүтэцтэй давхцаж байгаа тул газрын байршлыг замын баруун талд буюу төв худгийн хойно шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж газрын төлбөрийг хугацаанд нь төлж, Газрын тухай хууль болон гэрээнд заасан заалтуудын дагуу эзэмшихийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

3.Газар эзэмшилтэд хяналт тавьж гэрээ байгуулан ажиллахыг Газрын даамал (Б.Урансайхан)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/62 дугаар захирамжийн 1 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.МӨНХХУЯГ



010000421

Сумын Засаг даргын
2025 оны 07 сарын 29-ний өдрийн
А/138 тоот захирамжийн хавсралт

№	Газар эзэмшигчийн					Газрын					өмнөх	
	Овог	Эцэг, эхийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Байнгын хаяг	Эзэмших хугацаа /жил/	Зориулалт	Байршил	Хэмжээ /м2 аар/	Нэгж талбарын дугаар	Захирамжийн огноо, дугаар	Байршил
1	Халбин	Сүхбаатар	Уянга	СИ73011509	Дадал, 4-р баг Баян-Овоо	58	Худалдаа үйлчилгээ	Дадал, 4-р баг Баян-Овоо Тэмүүжин гудамж	270	2303002842	2025-04-22 А/62, 1 дэх хэсэг	4-р баг, Баян-Овоо Тэмүүжин 219 тоот
									270			